

Мэдэгдэл

Огноо: 2016 оны 10-р сарын 25

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

Хэнд: Ерөнхий эрх мэдэлтэн; Бүсийн дал; гадас, номлол, дүүргийн ерөнхийлөгч; бишоп, салбарын ерөнхийлөгч; гадас, тойргийн зөвлөлийн гишүүд

Хэнээс: Санваарын болон Гэр бүлийн гүйцэтгэх зөвлөл (801-240-2134)

Сэдэв: Ижил хүйстэндээ татагддаг хүмүүст үйлчлэх нь

Ижил хүйстэндээ татагдах асуудлын талаарх шинэчлэн найруулсан дараах эх сурвалжууд хувь хүн, гэр бүл, тойргийн зөвлөлүүдэд одоо нээлттэй боллоо.

- LDS.org дээр Сайн мэдээний сэдвүүд хэсэгт нэмэгдэж орсон “Ижил хүйстэндээ татагдах нь” (хавсралтыг үзнэ үү)
- Сүмийн сургаалууд (хавсралтыг үзнэ үү)
- Түгээмэл асуудаг асуултууд (хавсралтыг үзнэ үү)
- Англи хэл дээр үзэх боломжтой Mormonandgay.lds.org вэбсайт
- Хэрхэн үйлчлэх талаарх эх сурвалжуудыг (ministering.lds.org) тойрог, гадасны зөвлөлийн гишүүд LDS.org дээрх Удирдагч, бичиг хэргийн ажилтны мэдээллийн сангаар дамжуулан арван хэл дээр ашиглах боломжтой.

Эдгээр эх сурвалжийг гадасны эсвэл тойргийн зөвлөлийн хурал дээр тоймлон үзэж болно.

Topics.lds.org дээрх *Сайн мэдээний сэдвүүдээс авав*

Ижил хүйстэндээ татагдах гэдэг нь ижил хүйстэй хүнд сэтгэл санаа, бие махбод, бэлгийн дур хүслийн хувьд сэтгэл татагдахыг хэлж байгаа юм. Ижил хүйстэндээ татагдах байдал хүн бүрийн хувьд харилцан адилгүй байдаг. Зарим хүн зөвхөн ижил хүйстэндээ татагддаг байхад зарим нь ижил ба эсрэг хүйстний аль алинд татагддаг.

Сүм ижил хүйстэндээ татагдах болон ижил хүйстэнтэй бэлгийн харьцаанд орох хоёрыг ялгаж салгаж авч үздэг. Ижил хүйстэндээ татагддаг буюу гомо, лесби, бисексуал хүмүүс Бурхантай гэрээнүүд хийж, сахиж мөн Сүмийн үйл ажиллагаанд бүрэн дүүрэн, зохистой оролцох боломжтой. Гомо, лесби, бисексуал хэмээн тодорхойлуулах эсвэл ижил хүйстэндээ татагдах байдал нь нүгэл биш бөгөөд аливаа хүнд Сүмийн үйл ажиллагаанд оролцох, дуудлага хүлээн авах, ариун сүмд ороход нь саад болохгүй.

Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал нь бидний аз жаргалын төлөөх Бурханы төлөвлөгөөний амин чухал хэсэг юм. Бэлгийн харьцаа нь гэрлэсэн, нэг нэгэндээ чин үнэнч байх амлалт өгсөн эрэгтэй, эмэгтэй хоёрын хооронд байхаар заяагдсан. Гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй болон ижил хүйстэн хүмүүсийн хоорондын бэлгийн харьцаа нь Тэнгэр дэх Эцэгийн маань хамгийн чухал хуулиудын нэгийг зөрчдөг бөгөөд бидний мөнхийн өсөлт хөгжилд саад болдог. Бэлгийн чиг хандлагаас үл хамааран ариун явдлын хуулийг зөрчсөн хүн бүр наманчлалаар дамжуулан Бурхантай эвлэрүүлэгдэж чадна. Бид Христийн дагагчдын хувьд ёс суртахуунгүй зан байдлыг эсэргүүцэж, Түүнтэй илүү адил болохыг хичээдэг. Бид Ариун Сүнсний удирдамжийг болон биднийг уруу татагдах үед хэрхэн халамжлахыг мэддэг Аврагчийн тусламжийг эрэлхийлдэг (1 Коринт 10:13; С ба Г 62:1-ийг үзнэ үү). Хэрэв бид бэлгийн харьцааны уруу таталтад бууж өгч, ариун явдлын хуулийг зөрчсөн бол наманчилж, өршөөл хүлээн авч мөн Сүмийн гишүүний бүрэн эрхээ эдэлж чадна.

Зарим хүний ижил хүйстэндээ татагддаг шалтгааныг бид тодорхой мэдэхгүй байж болох ч тэдний хувьд энэ нь ээдрээтэй бөгөөд бодит зүйл, хүмүүний амьдралын нэгээхэн бэрхшээл юм. Аврагч Есүс Христ бидний дэлхий дээр туулж буй бэрхшээл бүрийг бүрэн ойлгодог учраас бид тайтгарал, баяр баясал, найдвар, удирдамж авахаар Түүнд хандаж болно (Алма 7:11–12-ыг үзнэ үү). Бидний амьдралд ямар ч сорилт тулгарсан бай, бид бол Бурханы хүүхдүүд бөгөөд нэг нэгнийхээ энэрэл, өрөвч нинжин сэтгэлийг хүртэх эрхтэй юм (Ром 8:16–17). Бид бие биенээ дэмжиж, нэг нэгэндээ илүү их энэрэл, өрөвч сэтгэлээр хандвал нэгдмэл байдал, итгэлийнхээ үр шимийг хүртэж чадна.

Mormonandgay.lds.org-оос авав.

Бурхан бүх хүүхдэдээ хайртай

Биднийг үхлийг даван туулж, мөнх амьдралтай болоосой гэсэндээ Өөрийн Хүүг золиослол болгон өгсөн Бурханы хайрын хэр хэмжээ, цар хүрээг үүнээс өөрөөр илүү бүрэн дүүрэн харуулах зүйл үгүй билээ. “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан тул цорын ганц Хүүгээ өгсөн. Ингэснээр Хүүд итгэгч хэн ч мөхөхгүй, харин мөнх амьтай болох юм” (Иохан 3:16). Хүн төрөлхтний нүглийг цагаатгах, бүх л зовлон шаналал, шударга бус зүйлийн төлөөсийг төлөх, бүх хүний өмнөөс үхлийн хүлээсийг тайлж болохын тулд амиа өгсөн Есүс Христийн хайрыг үүнээс илүү илэрхийлэх зүйл огт үгүй (Алма 7:11–13-ыг үзнэ үү). “Нөхдийнхөө төлөө амиа зориулахаас өөр агуу хайр байхгүй” (Иохан 15:13).

2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган дээр ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф Бурханы хайрыг дүрслэхдээ:

“Бурхан хүний гадаад байдлыг хардаггүй. Бид харшид амьдардаг уу эсвэл нэг давхар жижиг байшинд амьдардаг уу, мөн царайлаг уу, царай муутай юу, нэрд гарсан уу эсвэл хэн ч мэдэхгүй мартагдсан нэгэн үү гэдэг нь Түүнд огт хамаагүй байдаг гэдэгт би итгэдэг. Бид дутагдалтай хэдий ч Тэрээр биднийг бүрэн дүүрэн хайрладаг. Бид хэдий төгс биш ч Тэрээр биднийг төгс хайрладаг. Бид өөрсдийгөө зүг чиг заагчгүй, хаягдсан хүмүүс гэж бодож болох ч Бурханы хайр биднийг бүрэн дүүрэн өлгийдөн авсан байдаг.

Тэрээр хэмжээлшгүй цэвэр, ариун нандин, дүрслэхийн аргагүй хайраар бялхан байдаг учраас биднийг хайрладаг. Бид түүх намтрынхаа улмаас Бурханд чухал байгаа юм биш. Харин бид Түүний хүүхдүүд учраас Түүнд чухал байгаа юм. Тэрээр бидний хүн нэг бүрийг хайрладаг” гэжээ (“Бурханы хайр,” 2009 оны 10-р сарын Ерөнхий чуулган).

Бурхан бид бүгдэд хайртай. Тэр өөр итгэл үнэмшилтэй мөн шашин шүтлэггүй хүмүүсийг ч хайрладаг. Тэр зовж зүдэрсэн хүмүүсийг төдийгүй баян, ядуу гэж ялгалгүй бүх хүнийг хайрладаг. Тэр бүх үндэстэнг, ямар ч соёл заншилтай мөн гэрлэсэн эсвэл ганц бие хүмүүсийг мөн ижил хүйстэндээ татагддаг буюу гомо, лесби эсвэл бисексуал хэмээх тодотголтой хүмүүсийг ч бас хайрладаг. Тэрээр биднээс Өөрийнх нь үлгэр жишээг дагаасай хэмээн хүсдэг.

Бидэнд Бурханыг болон бие биенээ хайрлах зарлигийг өгсөн

““Чи бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюунаараа өөрийн Бурхан Эзэнээ хайрла. Энэ бол агуу нь бөгөөд хамгийн чухал тушаал мөн. Удаах нь “Чи хөршөө өөрийн адил хайрла” гэсэнтэй адил юм” (Матай 22:37–39).

“Би та нарыг яаж хайрласан шиг та нар бие биеэ хайрлагтун. Энэ бол Миний тушаал” (Иохан 15:12).

Бид Бурханы зарлигуудыг сахиж (Иохан 14:15-ыг үзнэ үү) мөн бие биенээ хайрласнаар Түүнийг хайрлах хайраа харуулдаг (Иохан 13:34-ийг үзнэ үү). Хэрэв таны гэр бүлийн гишүүн эсвэл найз ижил хүйстэндээ татагддаг буюу өөрсдийгөө гомо гэж үздэг бол тэднийг хайрла. Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

“Та нар дотно байсан боловч хол байгаа хэн нэгэнтэй ойр байхыг хүсвэл юу хийх ёстойгоо мэднэ. Та нар тэдэнтэй ярилцах арга замыг олж, тэднийг сонсож мөн нэг нэгнийхээ төлөө ямар нэг зүйл хийх арга замуудыг эрж хайх болно. Энэ харилцаа хэр олон давтагдаж, хэр удаан үргэлжилнэ, та нарын хоорондын харилцаа төдий чинээ гүн гүнзгий байх болно. Хэрэв ярилцахгүй, сонсохгүй мөн хийх зүйлүүдээ хийхгүй удвал харилцаа сулрах болно. Бурхан бол төгс төгөлдөр, бүхнийг мэдэгч, харин та бид мөнх бус юм. Гэвч тэр бол бидний Эцэг бөгөөд биднийг хайрладаг төдийгүй сайн найзын адилаар өөрт нь ойртох боломжийг бидэнд олгодог. Та нар ч бас адил арга замаар буюу ярилцаж, сонсож мөн үйлдсэнээр үүнийг хийх болно” (“To Draw Closer to God,” 1991 оны 4-р сарын Ерөнхий чуулган).

Та нар бусдыг хайрлаж, тэдэнд үйлчилснээр Бурханыг хайрладаг гэдгээ харуулдаг. “Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлийг та нар мэргэн ухааныг сурч болохын тулд хэллээ; та нар бусдадаа үйлчилж байгаа нь та нар зөвхөн Бурхандаа үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тулд буюу” (Мозая 2:17).

Бие биенээ хайрлах гэдэг нь юу гэсэн үг вэ? Хайр санаа тавьдаг. Хайр сонсдог. Хайр энэрэнгүй. Хайр урам зориг өгдөг. Хайр нь хүний хамгийн эрхэм дээд чанар юм. Учир нь бид Бурханы хүүхдүүд бөгөөд “Бурхан бол хайр билээ” (1 Иохан 4:8). Сүүлчийн зоог дээрээ Аврагч “Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:35) хэмээн хэлсэн.

Бие биенээ хайрлах зарлиг нь биднээс өөр үзэл бодолтой хүмүүсийг ч хайрлахыг багтаадаг. Ахлагч Даллин Х.Өүкс

“Бид амьдралд тохиолдох олон төрлийн харилцаа холбоо, нөхцөл байдалдаа дасан зохицож амьдрах ёстой. Хэдийгээр үзэл бодлын зөрчил гарсан ч бид амин чухал эрхэм нандин зүйлсээсээ татгалзаж, орхихгүй байх ёстой бөгөөд Христийг дагалдагч бидний хувьд эрхэмлэдэг зүйлсийг маань хуваалцдаггүй, мөн тэдгээрийн суурь сургаалыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа хүмүүстэй энх тайван байдлаар зэрэгцэн амьдарч сурах хэрэгтэй. Бид бошиглолын илчлэлтээр мэдэж авдаг Эцэгийн авралын төлөвлөгөөний дагуу Түүний тушаалуудыг дагаж амьдарвал зохих газарт мөнх бус амьдралаар амьдарч байна. Тэрээр биднийг хайрладаг байсан шиг өөр соёл, шашин шүтлэгтэй хөршүүдээ хайрлах нь ч мөн энэхүү тушаалуудад ордог. Мормоны Номны нэгэн бошиглогчийн зааснаар бид “Бурханыг болон бүх хүмүүнийг хайрлах хайрыг агуулан урагш тэмүүлэх ёстой” хэмээн тайлбарласан (2 Нифай 31:20)” (“Бусдыг хайрлаж, өөр үзэл бодол бүхий хүмүүстэй зэрэгцэн амьдрах нь,” 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган).

Бурханы хайр нүглийг зөвтгөдөггүй. “Учир нь Их Эзэн бибээр нүглийг өчүүхэн төдий ч хүлцэн тэвчиж чадахгүй. Гэсэн ч наманчилж, Их Эзэний зарлигуудыг биелүүлдэг хүн уучлагдах болно” (С ба Г 1:31–32). Үүний нэгэн адил бид Бурханы зарлигуудыг дагаж, өмгөөлж хамгаалахдаа өчүүхэн төдий ч буулт хийх ёсгүй боловч Бурханы хэрхэн хайрладгийг бүхий л байдлаараа даган дуурайж, нэг ч хүнд гадуурхагдсан, ганцаардсан эсвэл найдвараа алдсан гэсэн мэдрэмж төрүүлэхгүйн тулд бие биенээ нээлттэй болоод бүрэн дүүрэн хайрлах ёстой.

Аврагч бидний бүх бэрхшээлийг төгс ойлгодог

“Учир нь бид одоо толинд бүдэг бадаг хардаг ч, харин дараа нь нүүр нүүрээ харна. Би одоо хэсэгхэнийг мэддэг ч, би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ харин дараа нь би бүрэн мэдэх болно” (1 Коринт 13:12).

Мөнх бус хүмүүс бидний ойлголт хязгаарлагдмал. Бид Нифайтай хамт “Тэрбээр хүүхдүүддээ хайртайг нь би мэднэ; тийм боловч бүх зүйлүүдийн утгыг мэдэх нь үгүй би” (1 Нифай 11:17) хэмээн тунхаглаж чадна.

Бид хувийн амьдралдаа хариулт, удирдамж эрэлхийлэх үедээ Бурханд, Есүс Христийн цагаатгагч золиослолд буй хүчинд найдаж болно. Есүс Христ дэлхийн нүглүүдийг өөр дээрээ авч, хүн төрөлхтний мэдэрч болох бүх л өвчин шаналал, зүдгүүрийг үүрсэн.

“Мөн тэрээр бүх төрлийн өвчин мөн зүдгүүрүүд мөн уруу таталтуудыг тэвчих болно; мөн энэ нь тэр өөрийн хүмүүсийн шаналал мөн өвчнүүдийг өөр дээрээ авах болно гэсэн тэрхүү үг биелэгдэж болохын тулд бөлгөө” (Алма 7:11).

Ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийг мэдрэх нь нүгэл биш бөгөөд бид хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээ сонгож чадна

Ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийг төрүүлдэг учир шалтгааны тухайд Сүм аливаа байр суурь баримталдаггүй. 2006 онд ахлагч Даллин Х.Өүкс

“Ижил хүйстэндээ сэтгэл татагдахтай холбоотой асуудлуудыг хамруулаад эдгээр эмзэг байдал эсвэл дур хүслээс болж үүссэн ямар ч зүйл дээр Сүмд байр суурь байхгүй” хэмээн тайлбарлажээ (2006 онд ахлагч Даллин Х.Өүкс, Ланс Б.Викмэн нартай хийсэн ярилцлага: “Ижил хүйстэндээ сэтгэл татагдах нь”).

Ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийг мэдрэх нь нүгэл биш. Ахлагч М.Рассэлл Баллард:

“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм ижил хүйстэндээ татагдах байдал олон хүний хувьд ээдрээтэй бодит зүйл байдгийг хүлээн зөвшөөрдөг гэдэг нь тодорхой. Сэтгэл татагдах нь нүгэл биш, харин хүслийнхээ дагуу үйлдэх нь нүгэл мөн. Хэдий хувь хүн ижил хүйстэндээ сэтгэл татагдах эсэхээ өөрөө сонгохгүй ч харин уг мэдрэмжиндээ хэрхэн хариу үйлдэл хийхээ сонгодог. Сүм Бурханы бүх хүүхдийг, тэр дундаа [ижил хүйстэндээ татагддаг хүмүүсийг] хайрлаж, ойлгож ажилладаг” (“The Lord Needs You Now!” Ensign, 2015 оны 9-р сар, 29).

Ижил хүйстэндээ татагдах нь нүгэл биш боловч энэ нь хэцүү түвэгтэй байж болно. Аливаа хүн ийм мэдрэмжтэй байх эсэхээ өөрөө сонгоогүй ч гэсэн Бурханы зарлигуудыг сахих амлалт өгч чадна. Ижил хүйстэндээ татагддаг буюу гомо хүүхдийн эцэг эх нь уг хүүхдээ халамжлах, хайрлах арга замыг сонгох хэрэгтэй. Сүмийн гишүүдийн хувьд бид тэдэнд элэгсэг дотно хандах нь зүйтэй.

“Мөн тэрээр тэднийг бүгд өөрт нь ирж мөн өөрийнх нь сайн сайхныг хүртэхийг урьдаг; . . . түүнд ирэх хэнээс боловч үл татгалздаг; . . . Бурханд бүгд адил” (2 Нифай 26:33).

Бурханы хуулиудын дагуу амьдардаг хүмүүс Сүмд бүрэн оролцоотой байж чадна

“Бурхан бол нүүр тал хардаггүй” (Үйлс 10:34).

Хэрэв бид Бурханы хуулиудад дуулгавартай байвал Тэр бидэнд мөнхийн баяр баясгаланг өгнө гэж амладаг бөгөөд амлалтуудаа үргэлж биелүүлдэг. Ижил хүйстэндээ татагддаг буюу өөрсдийгөө гомо гэж тодорхойлдог хүмүүс Бурханд амлаж, амласнаа дагах бүрэн чадвартай. Тэд Түүний гэрэлд алхаж чадна. Тэд Сүмийн үйл ажиллагаануудад бүрэн дүүрэн оролцож чадна.

“Хэрэв гишүүд ижил хүйстэй хүнд сэтгэл татагддаг боловч ижил хүйстэнтэй бэлгийн харьцаанд ордоггүй бол тэднийг ариун явдлын хуулиар амьдрахаар шийдэж, зөв бус бодол санаагаа хянадаг болоход нь удирдагчид дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Эдгээр гишүүн Сүмийн дуудлага хүлээн авч болно. Хэрэв тэд зохистой бөгөөд бусад бүх талаараа зөв зохистой бол ариун сүмийн бичигтэй байж, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч болно” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 21.4.6).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли:

“Бид тэднийг Бурханы хөвгүүд, охидын хувиар хайрладаг. Тэдэнд хянахад хүндрэлтэй, хүчтэй дур хүсэл байж магадгүй. Ихэнх хүн өөр өөр цаг үед ямарваа нэгэн хүсэл сонирхолтой байдаг. Хэрэв тэд тэдгээр сонирхлоо үйлдэл болгохгүй аваас Сүмийн бусад гишүүнтэй адил урагш алхаж чадна. Хэрэв тэд Сүмийн ариун явдлын хууль болон ёс суртахууны жишгүүдийг зөрчих аваас бусдын адил Сүмийн сахилгын арга хэмжээг хүртэх болно” гэж хэлжээ (“What Are People Asking about Us?” 1998 оны 10-р сарын Ерөнхий чуулган).

Аливаа хүний нөхцөл байдал ямар ч бай, тэрээр яг одоо Их Эзэний ажилд хувь нэмэр оруулж чадах бөгөөд итгэлтэй байдал нь Бурханы итгэлтэй хүмүүст амласан адислалуудыг одоо болон хойшид авчирна гэж хүсэн хүлээж болно. Ахлагч Д.Тодд Кристоффэрсон

“Хүн бүрд бэлэг мөн авьяас байдаг. Хүн бүр аль ч цаг үед тэнгэрлэг төлөвлөгөөг биелүүлэхэд хувь нэмрээ оруулж чадна. Сайн бөгөөд амин чухал, яг одоо амин чухал байгаа зүйлүүд нь төгс биш нөхцөл байдалд ч хийгдэж болно. Та нарын олонх нь чадах бүхнээ хийж байгаа. Мөнх бус байдлын хамгийн хүнд бэрхшээлүүдийг даван туулж яваа та бүхнийг хүүхдүүдээ өргөмжлөх зорилготой Бурханы төлөвлөгөөг өмгөөлөн зогсох үед бид бүгд та нарыг дэмжихэд бэлэн байдаг. Есүс Христэд итгэл найдвараа тавьсан хүмүүсийн хувьд Цагаатгал нь шударга бус бүх зүйлийг засах болно гэдгийг бид итгэлтэй гэрчилж байна. Эцэгийн хүүхдүүддээ өгөхөөр бэлтгэсэн бүхнээс багыг хүлээн авахаар сонгогдсон хүн гэж байхгүй” (“Гэрлэж, гэр бүлтэй болох шалтгаан,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган).

Ариун явдлын хууль Бурханы бүх хүүхдэд хамаатай

Бэлгийн харьцааны цэвэр ариун байдал нь бидний аз жаргалын төлөөх Бурханы төлөвлөгөөний амин чухал хэсэг юм. Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга

“Адам, Ева хоёрт Бурханы өгсөн анхны зарлиг бол тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүддээ өгсөн “өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэ” хэмээсэн зарлиг хүчин төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “үр удмаа үлдээх энэхүү нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээн Бурхан зарлигласныг тунхаглаж байна” гэж тунхаглажээ (“Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”).

Гэрлээгүй эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн эсвэл ижил хүйстэн хүмүүсийн хоорондын бэлгийн харьцаа нь Тэнгэр дэх Эцэгийн маань хамгийн чухал хуулиудын нэгийг зөрчиж, бидний мөнхийн өсөлт хөгжилд саад болдог.

“Ариун явдлын тухай Их Эзэний хууль бол хууль ёсны гэрлэлтээс гадуур бэлгийн харьцаанд орохоос татгалзаж, гэрлэлтэндээ үнэнч байх явдал юм. Зөвхөн хууль ёсоор нөхөр, эхнэр болж хуримласан эрэгтэй, эмэгтэй хоёрын хоорондох бэлгийн харьцаа зүй ёсных байдаг. Садар самуун, завхайрал, ижил хүйстний хоорондох бэлгийн харьцаа, түүнчлэн ариун бус, гаж буруу хийгээд зохисгүй үйлдэл нь нүгэл юм” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 21.4.5).

Бэлгийн чиг хандлагаасаа үл хамааран ариун явдлын хуулийг зөрчсөн хүмүүс наманчлалаар дамжуулан Бурхантай эвлэрүүлэгдэж чадна.

“Чи садар самууныг үйлдэх ёсгүй; мөн садар самууныг үйлддэг, мөн үл наманчилдаг тэрээр зайлуулагдах ёстой. Гэвч садар самууныг үйлдсэн тэрээр мөн бүх зүрх сэтгэлээрээ наманчилж, мөн үүнийг орхиж, тэгээд үүнийг дахиад эс үйлдвээс, чи уучлах ёстой” (Сургаал ба Гэрээ 42:24–25).

Mormonandgay.lds.org-оос авав

Яагаад “ижил хүйстэндээ татагдах” гэдэг нэршлийг ашиглах болсон бэ? Яагаад зүгээр л “ижил хүйстэн” гэж хэлээгүй вэ?

Ижил хүйстэндээ татагдах гэдэг нь сэтгэл санаа, бие махбод, хайр сэтгэл эсвэл бэлгийн харьцааны хувьд ижил хүйстэндээ татагдахыг хэлдэг. Хэрэв та ижил хүйстэндээ татагддаг бол өөрийгөө тодорхойлох бэлгийн чиг хандлагын нэршлийг ашиглах эсэхээ сонгож болно. Ижил хүйстэндээ татагдах гэдэг нь хэн нэгэнд буруу зөрүү нэршил оноохоос зайлсхийж өгсөн ерөнхий нэр юм. Энэ вэбсайт нь ямар нэг нэр зүүхээс татгалзаж байгаа хүмүүсийг төлөөлж мөн гей, лесби эсвэл бисексуал хүмүүсийг үгүйсгэхгүйн тулд энэ нэршлийг ашигладаг.

Яагаад энэ вэбсайт хүйсийн чиг хандлагын өөрчлөлт эсвэл трансжендерийн асуудлуудын талаар сөхөж ярьдаггүй вэ?

Энэ вэбсайт дээр тавигдсан ерөнхий зарчмуудын олонх нь (жишээлбэл, хүлээн зөвшөөрөх ба нинжин сэтгэлээр хандахын ач холбогдол) хүйсийн чиг хандлагын хувьд өөрчлөгдсөн эсвэл трансжендер хожмын үеийн гэгээнтнүүдэд хамаатай. Гэхдээ ижил хүйстэндээ татагдах ба хүйсийн чиг хандлагын өөрчлөлттэй байх гэдэг нь хоёр өөр зүйл юм. Жишээлбэл, хүйсийн чиг хандлагын өөрчлөлттэй хүмүүс ижил хүйстэндээ татагддаг эсвэл татагдахгүй байж болдог бол ижил хүйстэндээ татагддаг хүмүүсийн дийлэнх нь хүйсээ солиулах хүсэлгүй байдаг. Сэтгэл зүйн болон хуулийн талаас авч үзвэл энэ хоёр нь ялгаатай зүйлүүд юм.

Та ижил хүйстэн мөн эсэхээ өөрөөсөө асууж байна уу?

Та ижил хүйстэн мөн эсэхээ өөрөөсөө асууж байгаа бол ижил хүйстэндээ татагдаж байсан ба эдгээр мэдрэмжийг юу гэж тайлбарлах тухайд гайхдаг байж болох юм. Бэлгийн дур хүсэл нь ярвигтай бөгөөд олон хүчин зүйлээс хамааралтай байдаг. Хайр сэтгэлийн болон оюун санааны байдал эсвэл бэлгийн дур хүсэл нь бэлгийн чиг хандлагыг илтгэж болох боловч байнга ийм байдаг гэж ойлгох ёсгүй. Бэлгийн дур хүсэл нь хувирч, өөрчлөгдөж болдог. Хэрэв та үүнийг асууж байгаа бол өөрийнхөө бэлгийн чиг хандлагын талаар дүгнэлт хийх гэж өөрийгөө шахаж шавдуулах хэрэггүй.

Аливаа үг хүмүүсийн хувьд өөр өөр утгатай байдаг бөгөөд ямар нэг үгийн тодорхойлолт бидний амьдралын туршид өөрчлөгдөж болдог. Таны хувьд *ижил хүйстэн* гэдэг үг ямар утгатай вэ? Энэ нь мэдрэмж үү? Тодорхойлолт уу? Аль эсвэл амьдралын хэв маяг уу? Нийгэм, соёл өөрчлөгдөхийн хэрээр *ижил хүйстэн* гэдэг үгийн хэрэглээ өөрчлөгдсөөр ирсэн. Ижил хүйстэн гэсэн тодорхойлолт нь та ижил хүйстэндээ татагддаг боловч энэ мэдрэмжийнхээ дагуу үйлдэх сонголт хийдэггүй гэсэн утгатай байж болно. Эсвэл энэ

нэршил нь та сэтгэл санаа, бие махбод, бэлгийн амьдрал эсвэл улс төрийн хувьд өөрийгөө хэрхэн илэрхийлдгийг тодорхойлдог байж болно. Хэн нэгэн хүн “би ижил хүйстэн” гэж хэлбэл түүнээс ямар утгаар хэлж байгааг нь асуугаарай.

Би өөрийгөө илчлэх хэрэгтэй юү?

Зарим хүний хувьд ижил хүйстэндээ татагдах мэдрэмжээ нууцлах нь ичиж зовох юм уу өөрөө өөртэйгөө зөрчилдөхөд хүргэж болно. Ийм мэдрэмжийнхээ талаар итгэж явдаг хүнтэйгээ хуваалцах нь сэтгэл санааг тайвшруулах, анагаах чадвартай байдаг. Гэсэн хэдий ч зарим хүн энэ тухай хэлэхээ арай азнадаг байж эсвэл мэдрэмжээ илүү цөөн хүнд хэлдэг байж гэж хүсдэг. Тиймээс энэ шийдвэр нь өөрийгөө олон нийтэд “илчлэх” эсвэл ижил хүйстэн гэдгээ ил тод зарлах гэсэн ямар ч шахалт, шаардлагад үндэслэх ёсгүй. Хэрэв та ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийнхээ талаар хуваалцахаар шийдсэн бол энэ тухайгаа хэнд хэлэх, мөнх бус туршлагынхаа энэ хэсгийг хэрхэн хуваалцах талаар залбирч бодож үзээрэй.

Хэрэв та ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийнхээ талаар хуваалцахаар эсвэл ижил хүйстэн гэдгээ зарлахаар шийдсэн бол гэртээ болон сүм дээр хүмүүсийн дэмжлэг, хүндлэл, нинжин сэтгэлийн тус дэмийг авах хэрэгтэй. Бид аливаа зүйлийг ойлгож мэдэх явцдаа нэг нэгэндээ тэвчээртэй хандах шаардлагатай.

Сүмийн гишүүдийн хувьд бид бүх ах, эгчийнхээ төлөө халуун дотно бөгөөд хайраар дүүрэн орчинг бий болгох үүрэгтэй. Иймэрхүү тусалж дэмжсэн харилцаа холбоо нь мөнх бус амьдралд сайн мэдээний дагуу амьдарч, Сүнснийг эрэлхийлэхэд хялбар болгодог.

Би эцэг эхтэйгээ эсвэл бишоптойгоо ижил хүйстэндээ татагдах мэдрэмжийн талаар хэрхэн ярилцаж болох вэ?

Хэрэв та эцэг эх, гэр бүлийн хэн нэг гишүүн, Сүмийн удирдагч зэрэгтэй чөлөөтэй ярилцаж чаддаг бол тэдэнд мэдрэмжийнхээ тухай хуваалцах талаар бодож үзээрэй. Юу мэдэрч байгааг тань ойлгоход тэдэнд тусал. Тэд таныг ойлгосон үедээ л таныг хайрлаж, дэмждэг гэдгээ харуулах болно. Хэрэв тэд үүнийг ойлгохгүй байвал энэ вэбсайт дээрх нийтлэлүүдийг уншихыг тэднээс хүс. Ийм харилцан яриаг эхлүүлэхэд амар хялбар биш байж болох ч ярилцдаг байх нь чухал юм. Эргэн тойрныхоо хүмүүст тэвчээртэй хандаж, хэн хүнгүй бүгд суралцаж байгаа гэдгээ санаарай. Хэрэв таны хайртай хүмүүс сайн ойлгохгүй эсвэл дэмжихгүй байвал тэдэнд таны тусламж хэрэгтэй байж болно. Эцэг эх, удирдагчдаа өөртөө нинжин сэтгэлээр, хүндэтгэлтэй хандаасай гэж хүсдэг шигээ тэдэнд ханд. Энэхүү вэбсайт нь ижил хүйстэндээ татагдах байдлыг сайн мэдээний талаас илүү сайн ойлгоход нь хүн бүрд туслах зорилготой.

Хэрэв би хангалттай итгэлтэй байвал ижил хүйстэндээ сэтгэл татагдах мэдрэмж арилах уу?

Ижил хүйстэндээ татагдах мэдрэмж нь таны итгэлтэй байдлын хэмжүүр биш. Олон хүн дуулгавартай байхын тулд олон жилийн турш залбирч, чадах бүхнээ хийдэг ч ижил хүйстэндээ татагдсан хэвээр байдаг. Ижил хүйстэндээ татагдах мэдрэмж хүчтэй эсвэл сул байх нь хүн бүрийн хувьд харилцан адилгүй. Зарим хүн ижил болон эсрэг хүйстний аль алинд татагддаг бол зарим хүн зөвхөн ижил хүйстэндээ татагддаг. Зарим хүний хувьд ижил хүйстэндээ татагдах мэдрэмж нь цаг хугацаа өнгөрөх тусам багасч болно. Аль ч тохиолдолд эцэг эхчүүдийн эсвэл удирдагчдын зүгээс энэ мэдрэмж өөрчлөгдөх ёстой гэсэн хүлээлт эсвэл шаардлага байх ёсгүй.

Ижил хүйстэндээ татагдах мэдрэмжээ хянаж чадахгүй байж болох ч хэрхэн хариу үйлдэл үзүүлэхээ сонгож чадна. Энэ туршлагаас юу сурч болох, энэ нь хэрхэн таны давуу тал болж болохыг Их Эзэнээс

асуух нь итгэлээ хянаж болохуйц үр дүнд хүргэдэг. Амьдралаа Бурханд зориулах нь итгэлийн нэгэн чухал үйлдэл бөгөөд одоо агуу адислалыг мөн ирэх дэлхийд илүү агуу адислалыг авчирдаг.

Сүм хэзээ нэгэн цагт сургаалаа өөрчилж, ижил хүйстний гэрлэлтийг зөвшөөрөх болов уу?

Бурханы төлөвлөгөөний төвд байдаг эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлтийн сургаал нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн салшгүй чухал сургаал бөгөөд өөрчлөгдөхгүй.

“Эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт бол судрууд дээр суурилсан сургаалын зарчмын хувьд Бурханы хүүхдүүдийн мөнхийн хувь тавилангийн төлөөх Бурханы төлөвлөгөөнд нэн чухал үүрэгтэйг Сүм нотолдог.

Зөвхөн хууль ёсоор нөхөр, эхнэр болон хуримласан эрэгтэй, эмэгтэй хоёрын хоорондох бэлгийн харьцаа зүй ёсных байдаг. Бэлгийн аливаа өөр харьцаа, түүний дотор ижил хүйстэй хүмүүсийн хоорондох бэлгийн харьцаа нь бурханлагаар бүтээгдсэн гэр бүлийн харилцааг доромжилж буй хэрэг юм. Гэрлэлт бол эрэгтэй, эмэгтэй хоёр хүний хоорондох хууль ёсны нэгдэл мөн гэдэг тодорхойлолтыг Сүм зөв гэж үздэг” (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь*, 21.4.10).